

## МОНГОЛ-ТАТАРЫН УГСАА-ТҮҮХИЙГ НЭХЭН СУРВАЛЖЛАХ НЬ

П.Дэлгэржаргал

Монгол Улсийн Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

[Deegii2001mn@yahoo.com](mailto:Deegii2001mn@yahoo.com)

**Өгүүллийн товч утга:** Түрэг угсааны улсуудын үеийн Монгол аймгуудын түүхийг судлах нь Монголчуудын төрт ёсны уламжлал, соёл, угсаа-түүхийн залгамж шинж чанарыг тодруулахад нэн чухал ач холбогдолтой. Өгүүлэн буй үеийн Монгол угсааны аймгуудын түүх нэн бүдэгрэн, сурвалж бичигт бараг тэмдэглэгдэн үлдээгүй байна. Энэ үед Монгол аймгуудын зарим хэсэг нь Эргүнэ гүн тийш нүүдэллэн одож, үлдсэн Монгол угсааны аймгууд нутгийнхаа зүүн тал руу шахагдсан ч өөрсдийн төр ёс, соёл, ахуйн уламжлалаа хадгалан "Гучин Татар", "Есөн Татар" хэмээн нэрлэгдэн Татарын нэгдэл-холбоо, ханлиг хэлбэрээр оршин тогтносоор байжээ. Энэхүү өгүүлэлд Түрэг угсааны улсуудын үед Татар хэмээх нэрээр түүхийн сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн аймгуудын угсаа-түүхийн асуудлыг тодруулахыг зорьсон болно.

**Түлхүүр үг:** Монгол угсааны аймгууд, Мэнгу шивэй, Таньтань (Датань), Гучин Татар, Есөн Татар, Кимадын нэгдэл.

Түрэг угсааны улсуудын үеийн Монгол аймгуудын талаарх Хятад сурвалжуудын мэдээ хомс төдийгүй хоорондоо зөрүүтэй, зарим нь эндүү ташуу байдгаас энэ үеийн Монгол аймгуудын түүх нэлээд маргаантай, судлаачдын санал дүгнэлт нэгдмэл биш байх нь олонтаа.

Өнөөгийн судалгааны түвшинд түрэг угсааны улсууд монгол нутагт ноёрхож байх үеийн Монгол угсааны аймгуудын түүхийн судалгаанд: 1) "Эргүнэ гүн"-ийн домогтой холбон тайлбарладаг, 2) Шивэй аймгууд болон Мэнгу шивэй аймагтай холбон үздэг, 3) Татар нэрийн дор ханлиг, хант улсын хэлбэрээр оршин тогтнож байсан гэдэг, 4) Татар, Шивэй аймгуудыг адилтган үздэг гэсэн түүх бичлэгийн дөрвөн ерөнхий хандлага байна хэмээн үзэж болохоор байна. Харин академич Ж.Болдбаатар VI-X зууны Монголчуудыг:

"1.Нэг хэсэг нь Түрэг, Уйгар зэрэг түрэг угсааны улсуудын бүрэлдэхүүнд орж, үндэс угсаагаа хамгаалан тэмцэж явжээ.Төрөлх нутагтаа үлдсэн Монголчуудаас эр зориг, эрдэм чадлаараа шалгарсан нь Түрэгийн төр, захиргааны байгууллагад алба хааж, Түрэгийн төрийн байгуулалд Монголын төр ёс, хууль цаазны уламжлалаа алхам алхмаар шингээж байв.

2. Рашид-Аддины "Судрын суулган"-д тэмдэглэсэнчлэн түрэгүүдийн довтолгоонд нэрвэгдэн устаж, зөвхөн хиян, нукус хэмээх хоёрхон овог амь өрсөн зугтаж гарсан. Тэд дүрвэн зайлж, Эргүнэ кун хэмээх бөглүү газар ирж, дөрвөн зууныг элээн суурьшжээ.

3. Энэ үед Монгол нутаг дээр түрэг угсааны хүчирхэг улсууд мандаж байсан боловч, нутгийн зүүн хэсэгт Татарын ханлиг бие даан оршиж байсан"<sup>1</sup> хэмээн гурав хуваан үзсэн нь энэ үеийн Монгол аймгуудын түүхийг цогцолбороор нь авч үзэх гэсэн арга зүйн шинэ хандлага мөн.

Ихэнх судлаачид энэ үеийн монгол аймгуудын түүхийг судлахдаа түүх бичлэгийн дээр дурьдсан чиглэлийн аль нэгийг баримталдаг өрөөсгөл хандлагаас зайлсхийж, цогцолбороор нь авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Судалгааны өнөөгийн түвшинд эл үеийн монгол аймгуудыг гурав хуваан үзэж болно. Үүнд:

1. Монгол угсааны зарим овог, аймгууд шивэйгийн нутагт шилжин суурьшсаныг Хятад сурвалжид "мэнгу шивэй" нэрээр тэмдэглэжээ.

<sup>1</sup> Дэлхий дахины түүх. I боть.(ред.Ж.Болдбаатар, З.Баасанжав).УБ., 2002. 113-114 дэх тал

2. Монгол угсааны аймгуудын ихэнх нь нутгийнхаа зүүн тал руу шахагдсан ч өөрсдийн угсаа гарал, соёл ахуй, төр ёсны уламжлалаа хадгалан "татар" хэмээн нэрийдэн оршин байсан.

3. Татар аймгуудын зарим нь Түрэг угсааны аймгуудтай айлсан сууж, тэдний угсаажилт, соёлын хөгжилд хүчтэй нөлөө үзүүлсээр байсан төдийгүй угсаа соёлын шинэ нэгдэл үүсгэн оршин байсан нь ч бий. Тухайлбал, Кимакын нэгдэл үүсэхэд татарууд тэргүүлэх үүрэгтэй оролцсон бөгөөд тэдний ноёлох овгууд нь татарууд байсан<sup>2</sup> нь тодорхой байна. Нөгөө талаар Аварууд Төв Азиас гаралтай нь тодорхой бөгөөд тэд монгол угсааны аймгууд байсан байх магадлал нэлээд их байна.

Шивэй аймгууд болон Мэнгу шивэйгийн талаарх үзэл бодлоо бид өмнө нь зарим асуудлаар илэрхийлж байсан [Дэлгэржаргал, 2001., 2002 ] бөгөөд энэ удаа Татартай холбоотой асуудлыг хөндөн үзэхийг зорилоо.

Түрэг угсааны улсууд Монгол нутагт ноёрхож байх үед Хятад сурвалжуудад шивэй аймгуудын талаарх мэдээ нэлээд их тэмдэглэгдсэн боловч түрэг, уйгарын хөшөөний бичээсүүдэд шивэй хэмээх нэр огт тэмдэглэгдээгүй, харин "гучин татар" (отуз татар), "өсөн татар" (токуз татар) гэх аймгуудын нэр дурьдагдах болсон байна. Ямар ч гэсэн XIII зууны үед бусад улс, ард түмнүүд Монголчуудыг "Татарчууд" хэмээн нэрлэж байсан бөгөөд монгол угсааны олон аймгуудаас бүрдсэн Татарын хүчирхэг ханлиг оршин тогтнож, төв азийн түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэж байсан [МНТ, "Судрын чуулган"] зэрэг нь Монголчууд Татартай этнонимын болон угсаа гарвалын холбоотой болохыг баталж байна.

Руни бичгийн дурсгалуудын мэдээ нь VI-IX зууны үед Монгол нутагт оршин байсан нүүдэлчин аймаг холбоодын талаарх төсөөллийг бидэнд өгч чадах төдийгүй Рашид-Аддины "Судрын чуулган", "Монголын нууц товчоо", Хятад болон Араб хэлээрх сурвалжууд энэ үеийн Монгол аймгуудын талаар тодорхой хэмжээний мэдээллийг хойч үедээ үлдээжээ.

Хятад сурвалжид Жоужаны өөр нэг нэрийг "Татар" гэдэг хэмээн дурьдсан байдаг төдийгүй Түрэг, Уйгарын хаант улсуудын үеийн Руни бичгийн дурсгалуудад Татар гэдэг нэр олонтоо тэмдэглэснийг үндэслэн зарим судлаачид Түрэг угсааны улсуудын үеийн Монгол аймгуудыг Татар гэж нэрлэж байсан гэж үздэг.

"Сун шү"-ийн 95 дугаар бүлэгт "Гээзэгтэн боолууд (табгачи нар) ... Хятад улсыг эзэлснээс хойш жуйжуй (Жоужань) боолууд тэдний хуучин нутгийг эзлэн авсан. Тэр нутагт Хан улсын үеийн Хүннүгийн умард ордон мөн байх. Жуйжуйн нэг нэр нь Дадань, бас Таньтан гэдэг, мөн Хүннүгийн өөр аймаг юм"<sup>3</sup> гэснийг судлаачид Татар хэмээх угсаатны нэрийн талаарх Хятад сурвалжийн анхны мэдээ хэмээн үзэж байна. Доктор Г.Сүхбаатар "Монгол Нирун улс" (1992) бүтээлдээ Татар нэрийн гарлыг мөшгөн судлаад "Хятад сурвалж бичигт Жоужаныг нэрлэх өөр нэр болох Датань, Таньтань бол авиа зүй, түүхийн талаар нягтлахад хожмын монгол угсаатны нэгэн аймгийн нэр Татар гэдэг нэр мөн байна" гэсэн дүгнэлтийг хийжээ. "Датань, Таньтань гэдгийн тэр үеийн дуудлага С.Ф.Кимийн сэргээснээр da-dan гэж, Б.Карлегрөнийхээр dai-dan байгаа" нь Татар гэсэн үг мөн болохыг баталж байгаа төдийгүй Ван Говэйн нялтласнаар дада, дадань гэх мэтээр хятад сурвалж бичигт анх 842 оноос эхлэн тэмдэглэгдсэн Татар гэх угсаатны нэртэй яг дүйж байна<sup>4</sup> хэмээн үзжээ. Хятад сурвалж бичигт Жоужаныг нэрлэх өөр нэр болох Датань, Таньтань (Татар) нь Жоужаны Датань хааны нэрээс үүсэлтэй гэж Сүрбадрах үзсэнийг Г.Сүхбаатар дэмжсэн байна. "Нийтийн он тооллын 423 онд Жоужаньчууд нь умард Лян улсын цзюйцюй Мэн Сунийг цохин эвдэж, Ашина аймгийг олж (эзэлж), Алтай

<sup>2</sup> Peter B. Golden. Notes on the Qipchaq tribes: Kimeks and Yemeks. The Turks. Volume I. p. 660-670

<sup>3</sup> Сүхбаатар Г. Монгол нирун улс. УБ., 1992. 165 дахь тал

<sup>4</sup> Сүхбаатар Г. Дурьдсан зохиол.181 дэх тал

уулын өвөрт нутаглуулан Жоужаны хаант улсад төмөр хайлуулах ажил хийлгэв. Энэ үед Жоужаны Датань (хаан) дөрвөн аймгийг ноёрхож, хүний сэтгэлийг ихэд олсноор хүмүүс Датаныг л мэдэхээс биш, Жоужаны нэрийг мэдэхгүй байлаа. Иймээс өмнөд төрийн "Сун улсын бичиг"-т Датань буюу Таньтань-аар Жоужаныг нэрлэж байжээ. Ингэхлээр Жоужаны ард иргэдийг Татар буюу Таньтань гэж түрэгчүүд нэрлээд түрэгээс ялгаж байсан юм"<sup>5</sup> гэжээ. Эртний Хятад сурвалж бичгийг нягталж үзэхэд Жоужанчууд Датань /414-429/ хааны үед хамгийн хүчирхэгжин мандаж байсан бөгөөд "424 оны намар цагт Датаны цэрэг нь Юньчжуний газрыг довтлоход Тоба улсын Шицзу хаан өөрийн биеэр дайтахар мордоод гурван өдөр, хоёр шөнө явж Юньчжуний газар хүрч очиход Датань хааны морьт цэрэг Шицзу хааны цэргийг даруй тавин давхар бүслэн авч хомроглоход морьдын толгой давхарлаж байгаа нь шургааг модоор эгнүүлсэн хэрэм мэт харагдаж байсан"<sup>6</sup> хэмээн тэмдэглэснээс үзэхэд цэрэг зэвсгийн талаар ч ихээхэн хүчтэй байжээ.

Г.Учида датань, таньтань, татарыг нэг гэж үзжээ. Бидний хувьд Датань хааны нэрээс Татар гэх угсаатны нэр үүссэн хэмээн үздэг судлаачидтай санал нэг байна. Татарчууд нэгэн үед хүчирхэг улс байж, түрэг угсаатнуудыг эрхшээлдээ оруулж байсан болохоор татар гэх угсаатантай холбогдсон домог түрэг угсаатны дотор дэлгэрчээ<sup>7</sup>. Нирун (Жоужань) улс хүчирхэгжин мандаж байсны нөлөөгөөр нэг хэсэг түрэг аймаг Татар нэртэй болсон гэж үзүүштэй байна<sup>8</sup> гэж Г.Сүхбаатар үзжээ.

Угсаатны ухамсар, сэтгэлгээний адилслын хамгийн томоохон илрэл нь өөрсдийн нэр буюу этнонимоор илэрдэг байна. Угсаатны нэр /этноним/ нь угсаатны сэтгэлгээний адилслын гадаад илрэл бөгөөд угсаатны ухамсрыг шууд тусгаж байдаг тул угсаа гарвалын судалгаанд чухал ач холбогдолтой. Иймд монгол угсааны аймгууд хэдий үед ямар нэрээр нэрлэгдэж байсныг судлах нь нэн чухал юм.

Монгол угсааны аймгууд хэдий үеэс "Монгол" хэмээн нэрийдсэн нь төдийлөн тодорхойгүй маргаантай байгаа асуудал юм. Сурвалжийн мэдээнүүдээс үзэхэд Монгол хэмээх нэр угсаатны нэр болсон нь нэлээд хожим үед холбогдож байна. "Судрын чуулган"-д "Одоо монголчууд гэж нэрлэгддэг боловч угтаан ийм нэргүй байсан улс түмнүүд ... Учир нь энэ нэр хожим буй болжээ" хэмээн тодорхой заасан төдийгүй "Эргүнэ гүнд очсон хоёр хүн өсөж үржээд овог нь олон болсоор бүхэл бүтэн улс түмэн үүсчээ. Монгол гэдэг нэр тэдгээрийн овгийн нэр болоод, Монголчуудын үеэс энэ нэрээр бусдыг нэрлэж эхэлсэн учир Монголчуудтай төстэй бусад улс түмнийг нэрлэсээр байдаг юм. Монголчууд нь ч түрэг угсаатны нэг юм. Тэд тэнгэрийн ивээл хүртэн, дөрвөн зуу орчим жилийн дотор олон салаа болоод тоогоор бусдаас давж, хүчирхэгжсэний улмаас тэдгээр нутагт бусад нь тэдний нэрээр нэрлэгдэх болсон тул түрэгчүүдийн ихэнх хэсгийг Монголчууд гэж нэрлэж байдаг. Үүнээс өмнө татарчууд ялагч болсны улмаас бүгдийг татарчууд гэж нэрэлсэнтэй адил юм. Татарчууд бас Араб, Хиндустан, Хятадад бас нэр алдартай байна"<sup>9</sup> гэсэн нь "Монгол" гэдэг нэр нэлээд хожуу угсаатны нэр болсныг баталж байна. Эргүнэ гүнд очсон "Монгол" хэмээх овгийн нэр тэнд өсөж үржсэн нийт Монгол угсааны олон овог аймгуудыг нэрлэх ерөнхий нэр болж, тэдгээр овог аймгууд өөр өөрийн тусгай нэртэй боловч бүгд "Монгол" хэмээх ерөнхий нэрээр нэрлэгдэх болсон байна. Монгол аймгууд Эргүнэ гүнд 400 орчим жил оршин суухдаа өнөржин олширч, өсөж үржсэн төдийгүй хэл, угсаа-соёл, аж ахуй, зан заншил, психологи

<sup>5</sup> Сурбадрах . Монгол үндэсний язгуурын үүсэл. Бээжин, 1988

<sup>6</sup> Хандсүрэн Ц. Жужаны хаант улс. УБ.,1994. 17 дахь тал

<sup>7</sup> Сүхбаатар Г. Дурьдсан зохиол.183 дахь тал

<sup>8</sup> Сүхбаатар Г. Дурьдсан зохиол.184 дэх тал

<sup>9</sup> Рашид-Аддин. Судрын чуулган.(Сүрэнхорлоогийн орчуулга) УБ.,2002. 67 дахь тал

зэрэг угсаатны шинжээрээ нэгдмэл болсон төдийгүй угсаатан бүрэлдэх гол хүчин зүйл болох угсаатны нэгдмэл ухамсар (адилсал) үндсэндээ бүрэлдэн тогтсон гэж үзэж болно. Үүний тодорхой илрэл нь "Монгол" хэмээх нэгэн ерөнхий нэрээр нэрлэгдэн, бүгд өөрсдийгөө Монголчууд хэмээн үздэг болсон явдал юм. "... Нирун гэж нэрлэдэг тэдгээр нь нэр хүндтэй алдартай болсон, /чингээд/ тэр үед бусад аймаг монголчууд гэж нэрлэгддэггүй байсан боловч, цөм Монгол аймгууд шиг алдарших болжээ. Учир нь тэд эрт үед хэл зан үйлийн талаар багахан ялгаатай байсан боловч гадаад төрх, биеийн галбир, хоч, хэл, зан үйл авираараа нэг нь нөгөөтэйгөө ойролцоо байсан"<sup>10</sup> гэснээс үзэхэд монгол аймгууд Эргүнэ гүнээс гарч, эх нутагтаан эргэн ирж, угсаа-гарал, хэл соёл нэгтэй бусад аймгуудаа нэгтгэн хүчирхэгжсэний улмаас монгол угсааны олон аймгууд төдийгүй Түрэг угсааны зарим аймгууд ч "Монгол" хэмээн нэрийдэх болсон байна.

Рашид-ад-дины "Судрын чуулган"-д "Хэт их сүр, нэр хүндтэй байсан болохоор бусад түрэг овог нь нэр, зэрэглэл янз янз боловч тэдний нэрээр алдаршин, цөм татарчууд гэж нэрлэгддэг байв. Тэдгээр янз бүрийн овог нь өөрсдийгөө тэдэнд хамруулан тэдний нэрээр алдаршсанаа өөрсдийн сүр, нэр төр гэж үздэг байв"<sup>11</sup> хэмээн тэмдэглэжээ. "Судрын чуулган"-ны "...эрт үед монголчууд талын бүх түрэг аймгийн нэг нь байсан юм"<sup>12</sup>, "...Монгол аймгууд бол дүр төрх хэлээрээ хоорондоо төстэй нийт олон түрэг аймгийн бүлгүүдийн нэгэн байв", "...тоогоор бусдаас давж, хүчирхэгжсэний улмаас тэдгээр нутагт бусад нь тэдний нэрээр нэрлэгдэх болсон тул түрэгчүүдийн ихэнх хэсгийг Монголчууд гэж нэрлэж байдаг" гэх зэрэг мэдээнээс үзэхэд Төв Азийн нүүдэлчин овог аймгууд "Түрэг", "Татар", "Монгол" гэсэн ерөнхий нэрээр нэрлэгдэн алдаршиж байсан нь тодорхой байна. Рашид-Аддин Төв азийн хээр талын нүүдэлчдийн түүхийг а) талын түрэг аймгуудын ноёрхлын үе, б) татарууд түрэг аймгуудыг эрхшээлдээ оруулж, татар нэрээр бүгдийг нэрлэх болсон үе, в) Монголчуудын манлайллын үе гэсэн этнологийн гурван үе шатанд хуваан<sup>13</sup> авч үзсэн бөгөөд Төв Азид Түрэг, Татар, Монгол аймгууд ээлжлэн хүчирхэгжиж, аль аймгууд нь хүчирхэг байна, тэр аймгуудын нэрээр бусад нь нэрлэгддэг байсан гэж үзэж болохоор байна.

"Үүнээс өмнө татарчууд ялагч болсны улмаас бүгдийг татарчууд гэж нэрэлсэнтэй адил юм. Татарчууд бас Араб, Хиндустан, Хятадад бас нэр алдартай байна", "Одоо болохоор Хятад, Зүрчидийн хүмүүс нанхиад, уйгар, кипчак, туркмен, харлуг, калач бүх олзлогсад мөн монголчуудын дунд өссөн тажик хүмүүсийг монголчууд гэж нэрлэх болов. Энэ бүх угсаатны нийлбэр өөрсдийн сүр, нэр төрийн хувьд өөрсдийгөө монголчууд гэж нэрлэх нь ашигтай гэж үзэж байна. Үүнээс урьд өмнө л татар хүчтэй хүчирхэг байсны улмаас иймэрхүү явдал мөн байжээ. Энэ шалтгаанаар Хятад, Хинд, Синд, Чин, Мачины нутагт Хиргис, Келар, Башкир оронд, Дешт-и-Кипчакт умар зүгийн нутагт араб аймгуудад Сири, Егикет, Марроко/ магриб/-т бүх түрэг аймгийг татарчууд гэж нэрлэдэг байв"<sup>14</sup> гэсэн "Судрын чуулган"-ы мэдээнүүдээс үзэхэд тэдгээр Монгол угсааны аймгуудыг Татар хэмээн нэрлэж байсан нь тодорхой байна. Ийнхүү монгол угсааны аймгууд Татар нэрээр алдаршиж байсан нь зөвхөн Жоужань улсын Датань хааны үе болон түүний дараа үед холбогдоод зогсохгүй, Түрэг угсааны улсуудын үед ч нэгэн адил хамаарна. Доктор Л.Билэгтийн "Байгаа бүх өгөгдөхүүнүүд "татар" гэдэг нэр алдаршсан нь анхны түрэгийн хаант улсын байлдан дагуулах үйл явц бөгөөд багагүй хувь нь дараагийн зуунуудын кимадын

<sup>10</sup> Рашид-аддин. Дурьдсан зохиол. 67 дахь тал

<sup>11</sup> Рашид-аддин. Дурьдсан зохиол. 66-67 дахь тал

<sup>12</sup> Рашид-аддин. Дурьдсан зохиол. 67 дахь тал

<sup>13</sup> Кляшторный С.Г. Государства татар в центральном азии /дочингисова эпоха/. Mongolica.

К 750-летию "Сокровенного сказания". М., 1993 с.140

<sup>14</sup> Рашид-Аддин. Дурьдсан зохиол. 67 дахь тал

нүүдэлчидтэй холбоотой"<sup>15</sup> гэсэн дүгнэлтийг цаашид улам гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй юм.

Руни бичгийн дурсгалууд нь VI-IX зууны Төв азийн нүүдэлчин аймгуудын холбоо, бүрдлүүдийн талаар нэлээд бодитой мэдээллийг өгч байна. Эдгээр бичээсүүдэд "Татар"-ын талаар өгүүлж байгаа нь Рашид-Аддины "Судрын чуулган"-ы "Татар"-ын тухай мэдээг давхар баталж байгаа хэрэг юм. Күл-тегиний хөшөөний бичээсийн зүүн талын 4, 14 дүгээр мөр, өмнө талын 1 дүгээр мөр, Билгэ хааны хөшөөний бичээсийн зүүн талын 5 дугаар мөрөнд тус тус "Отуз Татар" (гучин Татар)-ын талаар, Билгэ хааны хөшөөний бичээсийн зүүн талын 34 дүгээр мөр<sup>16</sup>, Мюянчур ханы хөшөөний бичээсийн зүүн талын 13, 15 дугаар мөр<sup>17</sup>, Тариатын бичээсийн 11, 13, 23 дугаар мөр<sup>18</sup>, Хербис Баар (Кюлюг Йиге)-ын бичээсэнд<sup>19</sup> (Д.Д.Васильевынхаар "Токуз Тата<...>"<sup>20</sup>) "токуз Татар" (есөн Татар)-ын талаар тус тус өгүүлж байгаагаас гадна Узун оба (Зүүн овоо)-ын бичээсэнд "Татар" гэдэг нэр<sup>21</sup> дурьдагдаж байна.

Күл-тегиний гэрэлт хөшөөний зүүн талын 4 дүгээр мөрөнд: "нас эцэслэсэнд наран мандах зүүн зүгийн Бүкли чөлийн улс, нанхиад, төвд, апар, пүрүм, киргиз, гурван курыкан, отуз татар, кидан, татаби зэрэг өчнөөн олон улсын хүн ирж, уйлан хайлан оршуулсан"<sup>22</sup> хэмээн Буман хааныг оршуулах ёслолд гучин Татарууд оролцсон тухай өгүүлснийг "Татар"-ын талаарх руни бичгийн анхны мэдээ гэж судлаачид үздэг.

Күл-тегин болон Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсэнд "Өмнө зүгийн нанхиад улс, умраас токуз огуз, Баз хаан дайсагнан харшилдаж, киргиз, курикан, отуз татар, кидан, татаби нар цөм довтлов. Миний эцэг хаан энэ олон улстай байлдахаар 47 удаа цэрэглэж, 20 удаа байлдав"<sup>23</sup>, "Тэдний гэр ба өмчийг би хоосруулав. Тэгээд Огузууд, есөн Татартай нэгдэж (бид нар луу) ирэв. Агу-д би хоёр том тулалдаан хийв. Тэдний цэргийг би ялж, тэдний ард түмнийг эрхшээлдээ оруулав. Үүний дараа би ийм ихийг (эзлэн) авсны дараа (миний авга ах хаан үхэв). Тэнгэр биднийг ивээж, би өөрөө 33 насандаа (хаан болж), цагийг эзлэв" (?)<sup>24</sup> хэмээн өгүүлжээ. Руни бичгийн дээрх мэдээнд Буман хааны оршуулах ёслолд гадаадын олон улсын хамт гучин Татарууд оролцсоныг зориуд тэмдэглэснээс үзэхэд энэ үед тэд Түрэгийн эрхшээл нөлөөнд ороогүй байсан бөгөөд харин Түрэгийн хожуу хаант улс байгуулагдахад нанхиад, токуз огуз, киргиз, курикан, кидан, татаби нартай эвсэл байгуулан Түрэгийн эсрэг довтолжээ. "Миний эцэг хаан энэ олон улстай байлдахаар 47 удаа цэрэглэж, 20 удаа байлдав" гэснээс үзэхэд хүч тэнцвэртэй, олон удаагийн дайн тулаан болсон байна. Харин Огузууд ба Татаруудын нэгдсэн хүч Агу хэмээх газар Ашина аймгуудтай хоёр томоохон тулалдаан хийсэн боловч ялагджээ.

Доктор Л.Билэгт "Түрэг хэмээх нийлбэр нэрийн дор анхны Түрэгийн хаант улсын үед өөр өөр аймгууд багтан орж, хожим нь өөрийн нэгдлийг байгуулсан нь эргэлзээгүй. Энэ үеэр Монголын тал нутагт токуз огуз, отуз татаар, уч-курыкан,

<sup>15</sup> Билэгт Л. Татары и Монголы. Археологийн судлал. Т. XVI, F.10, УБ., 1996, 134 дэх тал

<sup>16</sup> Talat Tekin, Orhon yazitlari Kultigin, Bilge kagan, Tonyukuk. Stambul, 1988.

<sup>17</sup> Малов С.Е. Памятники Древнетюркской письменности монголии и киргизии. М.-Л., 1959, 31, 39 дэх тал

<sup>18</sup> Шинэхүү М. Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал. УБ., 1975. 75-76, 91 дэх тал

<sup>19</sup> Кляшторный С.Г. Государства татар в центральном азии /дочингисова эпоха/. Mongolica. К 750-летию "Сокровенного сказания". М., 1993 с. 141

<sup>20</sup> Васильев Д.Д. Корпус тюркских рунических памятников бассейна Енисея. Л., 1983, с.34, 71

<sup>21</sup> Кызласов И.Л. Рунические письменности евразийских степей. М., 1994. с. 189, 191

<sup>22</sup> Радлов В.В. Orhun. Атлас древностей монголии. (труды орхонской экспедиции). Санктпетербургъ, 1899. Ankara, 1995. с.70

<sup>23</sup> Радлов В.В. Дурьдсан зохиол. с.70

<sup>24</sup> Малов С.Е. Памятники Древнетюркской письменности монголии и киргизии. М.-Л., 1959, с.13, 21-22

татаби болон магадгүй чикийн болон карлук аймгуудын зарим хэсэг нь нүүдэллэж байжээ. Анхны Түрэгийн хаант улс унасны дараа Монголын тал нутагт хоёр аймгийн нэгдэл - тогуз Огуз, отуз Татар байгуулагдсан<sup>25</sup> гэж үзжээ. Гэвч "Гучин Татар"-ын илч төлөөлөгчид 552 онд нас барсан Буман хааныг оршуулах ёслолд оролцож байсан нь Татарууд Жоужан улсыг залгамжлагч, Жоужанаас уг үндэстэй болохыг нотлохын сацуу "Гучин Татар"-ын нэгдэл энэ үед нэгэнт оршин байсныг баталж байна. "Ашин овог хоёр дахь хаант улсыг байгуулахын төлөө тэмцэлдээ, тухайлбал, токуз огуз, кыргиз, карлук, чик, кидан ба татаби (кумоси) нартай дайтахад өөрийн эрхшээлд байсан аймгуудад тулгуурлаж байсны дотор татарууд орж байжээ"<sup>26</sup> гэж зарим судлаачид үздэг. Үнэхээр Түрэгийн үеийн хөшөөний бичээсүүдэд тэмдэглэсэн дараа дараагийн аян дайнуудад Татаруудтай дайтсан тухай өгүүлэхгүй байгаа нь Татар Ашины аймгуудтай цэрэг-улс төрийн холбоотон байсныг илтгэж болох боловч нөгөө талаар Түрэгийн хожуу хаант улсад цохигдсоноор Татарын сүр хүчин буурч, Төв Азийн улс төрийн давцанд идэвхитэй үйл ажиллагаа явуулалгүй нам жим, амар тайван суусан байж болох юм. Татарын нутаг улс төрийн төвөөс зайдуу нэлээд зүүн тийш байсан нь ийм боломжийг олгож байсан байх. Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсэнд "Өмнө зүгийн нанхиад улс, умраас токуз огуз, Баз хаан дайсагнан харшилдаж, киргиз, курикан, отуз татар, кидан, татаби нар цөм довтлов. Миний эцэг хаан энэ олон улстай байлдахаар 47 удаа цэрэглэж, 20 удаа байлдав" гэсэнд үндэслэвэл уг үйл явдал Билгэ хааны эцэг Ашины хоёрдахь хаант улс (Түрэгийн хожуу хаант улс)-ыг байгуулагч Күтүлүг буюу Элтэрэс хааны үед болжээ. Элтэрэс хаан 693 онд нас барсан учир уг үйл явдалуудыг 690-ээд онд болсон гэж үзэж болно. Элтэрэс хааныг түүний дүү Мого (өргөмжилсөн нэр нь Капаган) залгамжилсан бөгөөд "Тэгээд Огузууд, есөн Татартай нэгдэж (бид нар луу) ирэв. Агу-д би хоёр том тулалдаан хийв. Тэдний цэргийг би ялж, тэдний ард түмнийг эрхшээлдээ оруулав. Үүний дараа би ийм ихийг (эзлэн) авсны дараа ( миний авга ах хаан үхэв ). Тэнгэр биднийг ивээж, би өөрөө 33 насандаа (хаан болж), цагийг эзлэв" гэсэн Билгэ хааны хөшөөний бичээс Агуд болсон Түрэг болон Огуз, есөн Татарын байлдаан Мого хааны хаанчлал (693-716)-ын сүүл үед болсныг харуулж байна. Дээрх руни бичээсийн мэдээ болон Билгэ хаан (716-734) –ы үед хожуу түрэгийн хаант улс хамгийн хүчирхэг байсан зэргээс үзэхэд "есөн Татар"-ууд энэ үед Түрэгийн хаант улсын хараат байсан бололтой.

Нөгөө талаар гучин Татарын нэгдэл-холбооноос зарим аймгууд нь гарч Түрэг аймгуудтай зэрэгцэн орших болж, тэдний улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилт, угсаажилтанд чухал үүрэг гүйцэтгэсээр байжээ. Татарын нэгдэл-холбооны гол цөм хэсэг нь улам бүр зүүн тийш шилжин сууж, Түрэг аймгуудтай холилдолгүй, харьцангуй бүхэллэг байж, улс төрийн нэгдэлээ хадгалан ханлиг байдлаар оршин байсан бөгөөд тэднийг "Есөн Татар" хэмээн нэрийдэх болсон бололтой. Иймч учраас "гучин Татар"-ын холбоо тооны хувьд цөөрч Уйгарын үеийн гэрэлт хөшөөний бичээсүүдэд "токуз Татар" буюу "есөн Татар"-ын талаар өгүүлдэг төдийгүй "есөн Огуз"-ын тоо ч цөөрч "найман Огуз" хэмээх болжээ.

Гардизийн (XI зуун) мэдээлснээр кимакийн нэгдэл үүссэн нь татаруудтай бүрэн холбогдож байгаа бөгөөд XI зууны дунд үед перс хэлээр түүний бичиж үлдээсэн "Зайн ал-ахбар"-т Кимакийн гарлын талаар өгүүлсэн түүхэн домог ихэд сонирхол татаж байна. Гардиз бичсэнээр: "Татарын толгойлогч нас барахад түүний хоёр хүү үлдсэн. Том хөвгүүн хаант улсын эзэн болж, бага хөвгүүн түүнд атаархжээ. Бага хөвгүүнийг Шад гэдэг байв. Тэр ахын амийг хорлох гэсэн боловч азгүйтжээ. Өөрийн амийг аврахын тулд, амраг боол эмийн хамт ахаас оргон

<sup>25</sup> Билэгт Л. Татары и Монголы. Археологийн судлал. Т. XVI, F. 10, УБ., 1996, с. 127

<sup>26</sup> Билэгт Л. Дурьдсан зохиол. с. 127

зайлж том мөрөн байдаг, мод ан гөрөө ихтэй газарт ирж асар босгож суурьшжээ.” Цааш нь уг домогт “Татар удмын долоон хүн түүн дээр очсон: Ими, Имак, Татаар, Баяндер, Кыпчак, Ланиказ, Аджлад нар байв. Адуу байсан газар эл хүмүүс өөрийн эздийн адууг хариулж байв. [Тэнд] Бэлчээр үлдээгүй тул өвс хайхдаа Шадын байсан газар хүрчээ. Тэрээр “өөрийн хамт ангийн олз ихтэй буцаж байсан тул тэднийг дайлжээ. Тэд өвөл хүртэл үлдэв. Цас орсоны дараа тэд нутаг буцаж чадсангүй. Өвс ихтэй тул тэд өвлийн турш тэнд үлджээ.” Хавар өөрийн нэг хүнийг татааруудын бууц руу илгэжээ. “Тэр нутагтаа очоод “бүх газар нутаг сүйдэж хүнгүй болсныг үзэв. Дайсан ирж бүх ард түмнийг дэрэмдэн хяджээ. Аймгийн үлдэгдэл энэ хүн дээр уулнаас бууж ирж уулзав. Тэрээр хүмүүст Шадын байдлын талаар ярьж өгсний дараа Иртыш мөрөн рүү явжээ. Тэнд хүрэлцэн очсоны дараа хүмүүс Шадыг өөрийн удирдагч хэмээн хүндэтгэл үзүүлжээ. Бусад хүмүүс эл мэдээг сонсож энэ газар луу зүглэх болжээ. 700 хүн цугларчээ. Тэд урт хугацааны турш Шадад алба хаажээ. Үржин боожсоны дараа тэд хотуудаар тархаж долоон аймаг болжээ. Долоон аймгийг дээрх долоон хүний нэрээр нэрлэжээ.”<sup>27</sup> Эл түүх бүхэлдээ тод аман түүхийн шинж чанартай бөгөөд өөрийн аймгийн түүхийг мэддэг кимакийн язгууртны төлөөлөгчийн үгээр бичсэн бололтой. Түүхэн домогт өгүүлэгдэж байгаа шад цолыг Ашины удмын жононгуудад олгож байсныг бид мэднэ. Хэрэв язгууртан хүн түрэг аймгийнх, тэр тусмаа Ашины овгийнх байсан бол түүнийг татар гэж нэрлэх нь утгагүй зүйл бөгөөд түүхэн домог аймгийн дээдэс татар гаралтайг шууд зааж байна.<sup>28</sup> Үнэхээр Кимак аймгийн нэгдлийн цөмийг бүрдүүлэхэд татаарын оролцоо их байсныг нь энэхүү түүхэн домог нотолж байна. Уг домгийг тухайн үеийн Төв Азийн улс төрийн үйл явдлын өрнөлттэй холбон үзвэл, “гучин Татар”-ын нэгдэл задарснаар зарим татар аймгууд Иртыш мөрний эхрүү шилжин суурьшиж, улмаар энэ аймаг салаалан хожим нь Кимак нэгдлийн цөм болжээ гэж дүгнэж болохоор байна. Шинэ ноёрхох овог, аймаг бүрэлдэх явц уг аман түүхэнд голлон тусгагдсан бөгөөд үүнд татаруудын оролцоо тэргүүлэх үүрэг гүйцэтгэжээ. Нөгөө талаар тэдгээрийн дотор “баяндер” ба “кипчак” нэрс дурьдагдаж байгаа нь огуз ба кипчакийн нүүдэлчид Кимакийн нэгдэл бүрэлдэх явцад оролцож байсныг илэрхийлнэ. IX зууны дунд үеэр кимак нэгдлийн нүүдэлчдийн суурьшсан нутаг дэвсгэр Иртыш мөрөн хавийн нутгаас Арал тэнгис хавийн тал хүртэл нутгийг хамарч байжээ.<sup>29</sup> Б.Е.Кумеков кимакийн төрийг IX зууны эцэс X зууны эхэн үед үүссэн (Кумеков,1972. т.109) гэсэн бол, С.А. Плетнёва төр үүсэх үйл явц хамаагүй эрт эхэлсэн гэж үзжээ. Яагаад гэвэл эл шинэ улсын талаар Азид бэхжиж, улс төрийн мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэх болсоны дараа дурьдах болсон<sup>30</sup> (Плетнёва, 1982, т.97) гэж үзжээ. Ийнхүү татарын зарим аймгууд Кимакийн улс төрийн нэгдэл үүсэхэд голлох үүрэг гүйцэтгэж байхад, нөгөө хэсэг нь түрэг аймгуудтай айлсан сууж, тэдний угсаа-соёлын хөгжилд зохих хувь нэмрээ оруулсаар байсан гэж үзүүштэй.

Харин өөрсдийн нэгдмэл байдал, соёл ахуйн уламжлалаа хадгалан ханлиг хэлбэрээр оршин байсан “Есөн Татар”-ууд Төв Азийн улс төрийн амьдралд идэвхитэй оролцон найман Огузтай цэрэг-улс төрийн эвсэл байгуулан Уйгарын хаант улсыг эсэргүүцэн тэмцжээ.

Моюнчурын гэрэлт хөшөөний бичээсэнд “Үдэш орой нар жаргах үед би тулалдаанд оров. Тэгээд ялав. Гэгээтэй байхад тэд (ухран тарж зугтжээ), гэвч шөнө тэд (дахин) цуглажээ. Бэжүкүкт найман Огуз, есөн Татараас нэг нь ч үлдсэнгүй”, “Бургу гэдэг газар (тэднийг) би дөрөв дэх сарын ес дэх өдөр би тэдэнтэй тулалдаж бас ялав. Бас тэдний адуу, тэдний мал, тэдний охид ба

<sup>27</sup> Ахинжанов С.М. Кыпчаки в истории средневекового Казакстана. Алмата,1999. с.101-102

<sup>28</sup> Билэгт Л.Татары и Монголы. Археологийн судлал. Т .XVI, F.10, УБ ,1996

<sup>29</sup> Билэгт Л.Татары и Монголы. Археологийн судлал.Т .XVI, F.10, УБ.,1996, с. 130

<sup>30</sup> Билэгт Л. Мөн тэнд.

эмсийг би өөртөө авч ирэв. Тав дахь сард тэд миний хойноос ирэв. Найман Огуз, есөн Татар бүгд ирэв. Сэлэнгээс баруун (хойд) Йигук голын өмнөд рүү Сын-Баши хүртэл би (өөрийн) цэргээ байрлуулав.<sup>31</sup> хэмээн өгүүлжээ. Бэкүкүк болон Бургуд болсон тулалдаанд "Есөн Татар", "Найман Огуз"-ууд ялагдсан байна. Үүний дараа "Есөн Татар", "Найман Огуз"-ууд өөрсдөө ирж нэгдсэн гэж өгүүлсэн нь хараат болж, магадгүй холбоотны эвсэл байгуулсан хэрэг бололтой.

Татарын аймгийн холбоо нь Уйгарын хаант улсын хараат байсан талаар Хятадын XII зууны "Хуэй чжу лу" зохиолд (зохиогч нь Ван Мин цзи) "киданууд уйгурын хонь хариулдаг байсан, харин татарууд уйгурын үхрийг хариулдаг байв"<sup>32</sup> гэж бичжээ.

Тариатын Орхон бичигт "Тэнгэр хан мину морин цэрэг есөн татарын арван долоон цөөн буюруг, тонграда, сөнгүд мянган..... хүмүүн түүний тегин нараас минь үүнийг бичүүлэхэд хан миний торгон цэрэг (бие хамгаалах сахиулын цэрэг)-ийн ахлагч эрэлхэг эцэглэг Бэгээр эр, Чигши хоёулаа бага дархан гурван зуун торгон цэрэгтэй зогслоо"<sup>33</sup>, "Тэнд .....гурван харлуг (карлук) эр гахай жил есөн татар ..... есөн буюруг.... сөнгүд (сөнөд ?) жирийн ард түмэн мину эцэг Торян ханд өчлөө."<sup>34</sup> хэмээснээс үзэхэд Торян хааны хөшөөг босголцоход есөн Татарууд оролцсон ажээ. <<"есөн Татарын арван долоон сайд" байлцаж байсан нь Уйгарын хаант улсын бүрэлдэхүүнд орж байсан тэдний аймаг хүн ам олонтой байсныг гэрчилж байна >><sup>35</sup> хэмээн доктор Л.Билэгт үзжээ. Есөн Татарууд тухайн үеийн Төв Азийн улс төрийн амьдралд идэвхитэй оролцож байсан нь Моюунчарийн болон Торян хааны хөшөөний бичээсүүдэд тэмдэглэгдэн үлджээ. Өөрөөр хэлбэл, Есөн Татарын нэлээд хүчирхэг ханлиг оршин тогтнох болсон гэж үзэж болно. Доктор Г.Сүхбаатар "Энэ үед (Уйгар улсын үед. П.Д) Монгол-Татар улс Хэрлэн, Туул голын савыг эргүүлэн авч нутагласан байна гэж үзэх бүрэн үндэстэй байна, учир нь Уйгар улсын дурсгал Орхон Сэлэнгийн саваар байна"<sup>36</sup> хэмээжээ.

IX зууны эхэн үе гэхэд Татарын ханлиг Төв Азийн улс төрийн амьдралд идэвхитэй оролцдог хүчирхэг улс төрийн хүчин болсон байсан нь дараа дараагийн үйл явдлуудаас харагдаж байна.

Киргизийн хаант улсын үеийн Татар аймгуудын талаарх мэдээ харьцангуй бага байдаг.

Тувагийн Хербис Баарын ("Кюлюг Йиге"-ийн) руни бичгийн дурсгалд "Хорин долоон настайдаа өөрийн улсын төлөө токуз-татартай дайтахаар явлаа" гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд уг дурсгалыг VIII зууны I хагаст хамааруулдаг байна.<sup>37</sup> С.Г.Кляшторный Киргиз Татарын энэ дайныг 842 онд болсон гээд "Енисейн руни бичигт дурьдагдсан Кюлюг Йиге баатарын оролцсон 842 оны Кыргыз-татарын дайн нь урьд нөлөөгүй байсан киргиз, татар болон кидан нар улс төрийн тавцанд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болж, IX-X зууны Төв азийн харилцааг тодорхойлох болсон шинэ нөхцөл байдлын илэрхийлэл болсон"<sup>38</sup> хэмээн тэрээр дүгнээд "Татар улс Сучжоугаар төвлөрөн, Ганьсу, Дорнод Туркстаны нутагт оршин байсан гэсэн Гамильтоны үзлийг дэмжин, "IX-XII зуунд Ганьсу, Дорнод

<sup>31</sup> Малов С.Е. Дурьдсан захиол. с.31, 39-40

<sup>32</sup> Кычанов Е.И. Монголы в VI-первой половине XII в. Дальний Восток и соседние территории в средние века: История и культура Востока Азии. Новосибирск, 1980, с.143

<sup>33</sup> Шинэхүү М. Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал. УБ., 1975. 75-76 дахь тал

<sup>34</sup> Шинэхүү М. Дурьдсан зохиол. 91 дэх тал

<sup>35</sup> Билэгт Л. Татары и Монголы. Археологийн судлал. Т. XVI, F.10, УБ., 1996, с. 127

<sup>36</sup> Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. II. УБ., 1995. 24 дэх тал

<sup>37</sup> Кляшторный С.Г. Стелы Золотого озера. (К датировке енисейских рунических памятников). – Тигологиса: К семидесятилетию академика А.Н.Кононова. Л., 1976, с.258-67., Васильев Д.Д. Корпус тюркских рунических памятников бассейна Енисея. Л., 1983, с.34, 71

<sup>38</sup> Кляшторный С.Г. Государства татар в центральном азии /дочингисова эпоха/. Mongolica. К 750-летию "Сокровенного сказания". М., 1993, с.145



Туркстаны нутагт Татар улс оршин тогтнож байсан<sup>39</sup> гэжээ. Гэхдээ Кляшторный Татар улс байсан гэдэгт нэлээд үндэслэл гаргасан ч Татарын газар нутгийн талаар тодорхой үндэслэл гаргаагүй төдийгүй, тэдний угсаа гарлын талаар ямар нэгэн санаа оноо илэрхийгүй ажээ.

Үнэхээр тухайн үеийн Төв азийн улс төрийн нөхцөл байдлыг дүгнэн үзвэл Киргиз, Татар, Каданчууд Төв азид тэргүүлэх байр суурь гүйцэтгэх болсон байна. 842 оны үйл явдалтай холбогдуулж, Хятадын сурвалж бичигт Ли Дэся түшмэлийн захидалд "Татарууд Киргизын дайсан ба Уйгарын сүүлчийн хааны холбоотон"<sup>40</sup> хэмээн анх Татаруудыг тэмдэглэснийг дээрх руни бичигт дурдагдаж буй Киргиз Татарын дайнтай холбогдоно гэж судлаачид үздэг.<sup>41</sup> Энэ нь Татар хэмээх нэр аймаг, угсаатны нэрээр Хятад сурвалжид 842 онд анх тэмдэглэгдсэн гэж Ван Го Вэйн судлан тогтоосонтой таарч байна.

Харин доктор Г.Сүхбаатар "Их Нирун улс /330-555/ мөхсөнөөс хойш түүний үндсэн хүн ам нь одоогийн Монгол улсын нутгийн баруун, төв хэсгээс шахагдан зүүн талын хэсэг, хил зэргэлдээ нутагт очиж нутаглаж, төрийнхөө гол цөмийг хадгалан үлдэж, жижиг улс болон оршин тогтнож байжээ"<sup>42</sup> гэж бичсэн байдаг. "Гучин татар нь Төв азийн зүүн хойд нутгаар сууж ... тэдний нэр ямагт кидан лугаа хамт, Түрэгийн зүүн зүгт хийсэн аян дайны үйл явдлуудтай холбогдон гарч байгаа"<sup>43</sup> гэснээс үзэхэд Татарын нутгийг нэлээд зүүн тийш байсан гэж үзсэн бололтой. Киргизүүд Монгол нутагт хэдийд, хаагуур ноёрхлоо тогтоож, Монгол нутаг дахь нүүдэлчдийн түүх, хүн амын угсаажилтанд ямар үүрэг гүйцэтгэснийг нарийвчлан тодруулах нь Татарын түүхийг тодруулахад чухал учир холбогдолтой. Киргизүүдийг Хятан нар монгол нутгаас шахан гаргаагүй бөгөөд тэд яагаад Монгол нутгаас явсныг одоо хүртэл оновчтой тайлбарлаж чадахгүй байна. Энэ талаар "Монгол улсын түүх"-ийн тэргүүн ботьд "Киргизүүд нь ийнхүү Төв азийн ихэнх нутгийг эрхшээлдээ оруулсан ч тэнд удаан ноёрхож чадсангүй. Өмнө нь Төв азид ноёрлоо тогтоож байсан улс гүрнүүд Монгол орны төв нутаг Орхон голын хөндийд төвлөн төр улсаа байгуулж байсан бол Киргисүүд энэ уламжлалыг дагасангүй. Тэд ерөөс энэ нутагт суурьсан идээшихийг эрмэлзээгүй бололтой"<sup>44</sup> гэжээ. Харин Л.Н.Гумилев үзэж байгаар Х зуунд Монголын тал нутаг "цөл" болж, Түрэг хэлтэн ард түмэн түүний хязгаар руу нүүдэллэж, харин "Х зууны эцсээс тал нутагт Амур хавиас дахин суурьшиж эхэлсэн"<sup>45</sup> бол Е.И.Кычановынхоор Монголчууд "Эргүнэ гүн"-ээс гарч ирж Түрэгүүдийг Монгол нутгаас шахан гаргасан<sup>46</sup> ажээ. Доктор Л.Билэгт "Х зууны Монголын тал нутгийн нүүдэлчин аймгууд дээд зэргийн бутралтай байж, Киргизүүд өмнө нь Жужан, Түрэг, Уйгарын хаант улсуудтай адилхан буюу нэгтгэх үүргийг гүйцэтгэж байжээ. Мал аж ахуй хөтлөх арга эрс тэс ялгаатай байсан нь Киргизүүдэд энэ бүс нутагт бэхжин үлдэх боломж өгсөнгүй" гээд "Амбагян хаан Уйгарын хааныг хуучин нутагтаа ирэхийг урьсан нь нэг талаас Киданы холбоотнууд Монголын нүүдэлчдийг нэгдмэл байдалтай байлгах сонирхлыг, нөгөө талаас Киргизийн хаан тухайн бүс нутгийн нүүдэлчдийн хувьд сул үүрэг гүйцэтгэж (эсвэл бүр оролцоогүй) байсныг гэрчилж байна"<sup>47</sup> гэсэн сонирхолтой дүгнэлтийг хийжээ. "Тэдний ийнхүү явсан нь (Киргизүүд монгол нутгаас явсан нь. П.Д) эдийн засгийн шалтгаантай байж болохыг үгүйсгэх аргагүй бөгөөд уугуул нутагтаа газар

<sup>39</sup> Кляшторный С.Г. Дурьдсан зохиол. с.143-145

<sup>40</sup> Pelliot P. L'edition collective des oeuvres de Wang Kuo-wei. –TP,1929, p.125-126

<sup>41</sup> Кляшторный С.Г. Дурьдсан зохиол с.142

<sup>42</sup> Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. I. (ред. Д. Хүүхэнбаатар) УБ., 1995. 23 дахь тал

<sup>43</sup> Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2003. 353 дахь тал

<sup>44</sup> Мөн төнд. 348 дахь тал

<sup>45</sup> Гумилев Л.Н. В поисках вымышленного царство. М.,1992, с.52,54,75

<sup>46</sup> Кычанов Е.И. Монголы в VI-первой половине XII в. Дальний Восток и соседние территории в средние века: История и культура Востока Азии. Новосибирск, 1980, с.139

<sup>47</sup> Билэгт Л. Татары и Монголы. Археологийн судлал. Т. XVI, F. 10, УБ.,1996, с.132

тариалан голлон эрхэлж байсан Киргис нарын ахуй амьдрал нь, хэдийнээс бэлчээрийн МАА-д илүү тохирсон Монгол нутгийн уур амьсгалд зохимж муутай байсан нь бас нэгэн шалтгаан байсан бололтой. Ямар ч атугай Елюй Амбагян тэргүүтэй Хятан нар баруун зүг давшихад киргис нар Монгол нутагт байгаагүй гэдэг. Тэгээд ч Хятан нар уйгарыг хуучин нутагтаа ирж суурьшихыг санал болгож байжээ".<sup>48</sup> Ийнхүү Киргизүүд Төв азид байсан цаг хугацаа болон энэ нутгийг орхиж явсан шалтгааныг олон янзаар тайлбарладаг. Киргизүүд Уйгарын хаант улсыг мөхөөн Киргиз улсыг байгуулсан бөгөөд улмаар Төв азид дангаар ноёрхохыг зорьсон боловч тэдний энэ зорилгод Монгол угсааны аймгуудаас бүрдсэн "Татарын ханлиг" гол саад болох болсноор төдийлөн амжилтанд хүрээгүй гэж үзэх нь түүхэн үнэнд илүү нийцэж болох юм. Үнэхээр энэ үед Киргиз, Киданаас гадна тэдэнтэй өрсөлдөхүйц улс төрийн хүчин Төв азид гарч ирсэн нь Татарууд байсан байна. Доктор Г.Сүхбаатар судлан тогтоосноор Монгол татар улс Тан улсын түүхэнд 868 онд дурдагдсан бөгөөд "Татар Тан улсын эсрэг цэргийн бослогыг дарахад цэрэг туслан оролцож байснаас үзэхэд нэлээд хүчирхэг байсан нь илэрхий"<sup>49</sup> байгаа бол, судлаач Б.Батсүрэн "VIII зууны II хагасаас, хитан нар Төв ази, Монголын нутгийг эзлэх хүртэл хугацаанд татарууд өөрийн үндсэн нутгаас гадна монголын Хангайн нуруунаас урагш орших нутгийг, мөн Их Хинганы нуруунаас дорнод Туркстан, Ганьсу хүртэлх өмнөд монголын нутгийг тодорхой хэмжээнд хянаж байсан бол, киргизүүд хакас, тува, хийгээд монголын Тэсийн голын сав буюу баруун хойд хэсгийг хянаж байсан бололтой"<sup>50</sup> гэсэн саналыг дэвшүүлжээ.

Киргизүүд Монгол нутагт, ялангуяа дорнод Монголд ноёрхлоо тогтоож чадаагүй болон урьдын уламжлалыг даган төв Монгол Орхоны хөндийгөөр төвлөн төр улсаа байгуулаагүйг "Киданчууд Монгол нутгаас шахсан", "энэ нутагт суурьсан идээшихийг эрмэлзээгүй", "эдийн засгийн шалтгаантай", "Монгол нутгийн уур амьсгалд зохимж муутай байсан"-аас болсон гэх нь учир дутагдалтай бөгөөд Татар аймгуудын эсэргүүцэл тэмцэлтэй холбон тайлбарлах нь үнэнд илүү ойртох бизээ.

Хятан улс, Монгол-Татарын харилцааны түүх нь Татарын түүхийг тодруулахад чухал учир холбогдолтой.

"Монгол-Татар улс Хитан улстай элчин илгээн ердийн дипломат, ордны худалдаа хийх зэргээр харилцаатай байсны гадна үе үе харилцан довтолцдог байв. "Татар улс 918 оны хоёрдугаар сард элчин илгээн бэлэг барив" гэж Хитан улсын түүхэнд тэмдэглэх"-дээ "татар улс" гэж эрх тэгш эрхтэй улсын байдлаар тэмдэглэжээ. 918 оноос хойш ихэвчлэн улс гэх нэр хэрэглэлгүй Татар гэж нэрлэсэн<sup>51</sup> байгааг доктор Г.Сүхбаатар онцлон анзаарч тэмдэглэсэн байдаг. "Амбагян ... Кыргыз улсыг довтлон, 924 онд Хэрлэнгээс урагших, Алтайгаас зүүн тийших газар нутгийг эзэлж, тэндхийн аймаг угсаатнуудыг "... төрөл төрлөөр шилжүүлж, гурван аймаг зохиож", тэр зүгийн аймгуудыг Зү-бү (заримдаа Зү-бү улс) гэж нэрлэсэн байна. Тэр үеэс Зү-бү нар Хятан улсад харьяалагдсаны тэмдэг болгож алба хүргэн явсаар XI зууны эхэн хүрчээ".<sup>52</sup> Хятанчууд Зү-бү (Зүнь-бү) аймгуудыг хараат болгоод "Тайцзу хаан төрөл, төрлөөр шилжүүлж, гурван аймаг зохиож, ... хот балгас цогцолсонгүй, захын цэрэг тавьсангүй боловч, Зү-бү аймаг үе, үед болгоомжлон, дайн болсонгүй..."<sup>53</sup> гэжээ. Хятан гүрний түүхийн хятад хэлээрх мэдээ хэрэглэгдэхүүнээс үзвэл, Хятаны цэрэг 923, 924 онд монголоос байлдан эзэлсэн газрын баруун зах нь Алтайн уул хүрч, хойд зах нь Хэрлэн голд

<sup>48</sup> Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ., 2003. 348 дахь тал

<sup>49</sup> Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. I.(ред. Д.Хүүхэнбаатар).УБ.,1995. 24 дахь тал

<sup>50</sup> Батсүрэн.Б. Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр.УБ., 2003.73 дахь тал

<sup>51</sup> Ред. Д.Хүүхэнбаатар. Дурдсан зохиол. 25 дахь тал

<sup>52</sup> Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2003. 366-367 дахь тал

<sup>53</sup> Пэрлээ Х. Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь. УБ.,1959. 76 дахь тал

тулж байжээ. Хэрлэн голоос хойшх газрыг Хятан гүрний цэрэг эзэлсэн мэдээ байхгүй<sup>54</sup> бөгөөд Хэрлэн голоос хойшх монгол аймгууд Хятаны эрхшээл нөлөөнд ороогүй гэж үзэж болно. Нөгөө талаар X зууны сүүлч хүртэл Зү-бү аймгууд Хятаны хараат байдлыг тэмдэг болгож, их төлөв адуу малаар алба өргөх төдийгөөр хазгаарлагдаж байжээ. Монгол-Татарууд Хятаны хараат болсон боловч, үнэн хэрэгтээ бие даасан бодлого явуулж, Хятаны нөлөө төдийлөн их байгаагүй бололтой.

Энэ талаар Х.Пэрлээ "Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь" зохиолдоо "урьд эзэлсэн бөгөөд алба хүргэх төдийгөөр захирагдаж байгаагийнхаа тэмдэг болгож "дагах, урвах" нь тогтворгүй гэгдэж байсан баруун хойд (Монгол нутаг дахь) олон аймгаас улсынхаа алба татварын нэг хэсгийг гаргуулан мөлжих бодлогод шилжиж байжээ. XI зууны эхнээс, Хятан улсын баруун хойд хязгаарын (Монгол нутаг дахь) аймгуудын тэмцэл нь Хятан улсад алба барихгүй таслах, Хятаны хилийг довтлох төдий биш, харин Хятаны хаанаас аймагтаа томилон суулгасан түшмэдийг алж, хэд хэдэн аймгаараа хамтран бослого хийдэг"<sup>55</sup> байсан хэмээжээ. Иймд XI зууны үеэс Монгол нутаг дахь захиргаагаа чангатган, дарангуй цэрэг суулгах болжээ.

Ван Говэй зэрэг Хятадын эрдэмтдийн судалснаар Татар нь 928-1045 оны хооронд 17 удаа элчин илгээсэн буюу алба барьж байсан бөгөөд Татар, Хитан хоёр барих алба, худалдах зүйлийн талаар маргалдаж, Хитаны хааны 1019 оны зарлигаар татарууд урьдын адил 70000 мөр, 440 тэмээ барих болсон байна.<sup>56</sup> Хятад, Япон, Франц зэрэг улсын эрдэмтэд татар гэх нэр Хитан улс (907-1125), зүрчидийн алтан улс (1125-1235)-ын түүхэнд тэмдэглэгдсэн цзубу гэх нэртэй хэрхэн холбогдохыг хоёр угсаатны уугуул нутаг, үйл явдлын он цаг, хоёр нэр хитан улсын ба алтан улсын түүхэнд нэг нэгнийгээ орлон дурдагдсан байдал зэргийг харьцуулан судалсны үр дүнд одоогийн монгол улсын нутагт байсан монгол угсаантныг нэрлэх хоёр янзын нэр мөн болохыг тогтоожээ.<sup>57</sup>

Татарын Татар, Шивэй хоёрын хамаарлын талаарх маргаан одоо хүртэл судлаачдын дунд үргэлжилсээр байна.

Кумоси нь түрэгийн хөшөөний бичээсэнд татаби нэрээр гардаг<sup>58</sup> гэсэн Грумм-Гржимайлогийн үзэл, гучин татарыг шивэй аймгуудтай холбон үзэх гэсэн Ван Го Вэй, М.Шинэхүү, Л.Л.Викторова нарын саналыг үндэслэн "Монгол улсын түүх"-ийн тэргүүн ботьд "Эдгээр нь (кидан, кумоси, шивэй, П.Д) түрэгийн хөшөөний бичээсэнд кидан, татаби, гучин татар нэрээр тэмдэглэгдэн үлдэж, тухайн үеийн түүхэн үйл явдалд идэвхитэй оролцож байсан бөгөөд эдний дундаас хожмын монгол угсаатан бүрэлдэхэд гол үүрэг гүйцэтгэсэн нь шивэй, ялангуяа мэнгү-шивэй хэмээх аймаг болох юм. Үнэхээр ч гучин татар нь Төв азийн зүүн хойд нутгаар сууж байсан нь тэдний нэр ямагт кидан лугаа хамт, Түрэгийн зүүн зүгт хийсэн аян дайны үйл явдлуудтай холбогдон гарч байгаа хийгээд шивэй аймгуудын тоо ерөнхийдөө энэхүү гучин татар хэмээн онцолж тэмдэглэсэнтэй дүйж байгаа зэргээс үзэхэд нанхиад сурвалжид шивэй хэмээн тэмдэглэсэн аймгуудыг түрэгүүд гучин татар гэж нэрлэж байсан"<sup>59</sup> гэсэн дүгнэлтийг хийжээ. Академич Х.Пэрлээ "Шивэйн олон аймаг Тан улсын үед буюу VIII-IX зууны үед 30 гаруй тоонд хүрч байсан нь гучин татарын нэр анхан бичигт тэмдэглэгдсэн он цагт ерөнхийдөө дүйж байгаа нь сонин хэрэг"<sup>60</sup> хэмээн өгүүлсэн

<sup>54</sup> Пэрлээ Х. Хятан гүрний үеийн гурван мөрний эхний монгол аймгууд (907-1125). ЭШ-ий өгүүлүүд. II. УБ., 2001. 294 дэх тал

<sup>55</sup> Пэрлээ Х. Хятан нар, ... 80 дахь тал

<sup>56</sup> Ред. Д Хүүхэнбаатар. Дурдсан зохиол. 25 дахь тал

<sup>57</sup> Ред. Д Хүүхэнбаатар. Дурдсан зохиол. 24 дахь тал

<sup>58</sup> Грумм-Гржимайло Г.Е. Западная Монголия и Урианхайский край. Том. II. Л., 1926, с.163

<sup>59</sup> Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ., 2003. 353 дахь тал

<sup>60</sup> Пэрлээ Х. Гурван мөрний Монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь. Түүхийн судлал. Т.8, F.6, УБ., 1969, 122

байдаг. Ийнхүү зарим судлаачид Шивэй, Татар хоёрыг нэг байж магадгүй гэж үзсэн байхад шууд адилтган “Шивэйн 30 аймаг, 30 татар гэдэг нь нэг зүйл аж”<sup>61</sup> хэмээн бичсэн ч бий. Шивэйгийн түүхийг судалсан Хятадын зарим эрдэмтэд тэднийг угсаа гарлын хувьд нэгдмэл биш ч ихэвчлэн Манж, Түнгүс хэлтнүүд байсан хэмээн үздэг<sup>62</sup> төдийгүй Хятадын эрдэмтэн Чжэн Индэ түүхэн газар зүйн судалгаагаараа Шивэйгийн 22 аймгийн газар нутгийн байршлыг тогтоосон нь нэлээд дорвитой ажил болжээ. Хятад сурвалжуудын мэдээнээс үзэхэд Шивэй аймгуудын эрхлэх аж ахуй, зан үйл, ёс заншил нь Монголчуудынхаас нэлээд ялгаатай, өөр болох нь харагдаж байна.<sup>63</sup> Шивэйгийн аймгууд болон гучин Татар хэмээх нь нэг зүйл гэдэг нь гэрэлт хөшөөний руни бичээсүүд болон хятад сурвалжийн мэдээнүүдээр батлагдахгүй байна. Харин “Тан улсын судар”-т тэмдэглэгдсэн Мэнгу шивэй нь манж түнгүс угсааны Шивэй аймаг бус, харин Түрэгүүдэд цохигдон зүүн тийш шахагдаж, Шивэй аймгуудын нутагт шилжин суусан Монгол аймаг байсан байж<sup>64</sup> болохоор байна. Күл-тегин жанжин, Билгэ, Моюнчур, Торян хаадын гэрэлт хөшөөний болон Зүүн овоо, Хербис Баарын руни бичээсүүд Түрэг угсааны улсуудын үед төв болон зүүн Монголын нутагт “Татар” хэмээн нэрийдсэн Монгол угсааны аймгууд суурьшиж байсныг нотолж байгаа бөгөөд Татарын зарим аймгууд нь Түрэг аймгуудтай зэрэгцэн оршиж, тэдний угсаа соёлын хөгжилд хүчтэй нөлөө үзүүлсэн бол, үндсэн гол мөхлөг нь өөрийн улс төрийн нэгдэл, тусгаар тогтнол, төр ёс, соёл ахуйн уламжлалаа хадгалан “есөн Татар” хэмээн нэрийдэн оршин тогтнож байв. Өөрөөр хэлбэл, Түрэгүүдэд цохигдон Жоужань улс мөхөхөд, ноёлох овгийн нэг Монгол хэмээх овог аймаг Эргүнэ гүн тийш нүүдэллэн одож, үлдсэн Монгол угсааны аймгууд нутгийнхаа зүүн тал руу шахагдсан ч өөрсдийн төр ёс, соёл ахуйн уламжлалаа хадгалан “Гучин Татар”, “Есөн Татар” хэмээн нэрлэгдэн Татарын нэгдэл-холбоо, ханлиг, хэлбэрээр оршин тогтносоор байжээ.

Дээр өгүүлсэн сурвалжийн мэдээ занги, эрдэмтдийн судалгааны хаялгаас үзэхэд Татарын улс төрийн түүхийг дараах үеүдэд хуваан үзэж болохоор байна. Үүнд: А) Түрэг аймгуудад нутгийнхаа зүүн тал руу шахагдан ч Түрэгийн хаант улстай мөчөөрхөлцөн тэмцэлдэж байсан үе (Түрэгийн түрүү хаант улс болон Түрэгийн хожуу хаант улсын эхэн үе буюу 555 оноос 710-аад оны дунд үе).

Б) 710-аад оны дунд үед Татар болон Огузууд Агу-д болсон хоёр удаагийн тулалдаанд Түрэгийн хожуу хаант улсад цохигдсоноор “гучин Татар”-ын нэгдэл задарсан ч гол цөм хэсэг нь улс төрийн нэгдэлээ хадгалан, ханлиг хэлбэрээр оршин байсан үе. (715 оны орчмоос 740-өөд он).

В) Түрэгийн хаант улсын сүүл үеэс Татарууд нэлээд бэхжин Уйгарын үе гэхэд төв азийн улс төрийн давцанд идэвхитэй үйл ажиллагаа явуулах болжээ. Энэ үед “Есөн Татар” хэмээн нэрлэгдэж байв. Татарын зарим аймгууд Кимакын нэгдлийн гол цөмийг бүрдүүлсэн бол зарим аймгууд нь түрэг аймгуудтай айлсан сууж, угсаа-соёлын хөгжилд нь нөлөөлсөөр байжээ.

Г) Төв азийн хүчирхэг улс төрийн хүчин болж, Киргизүүдтэй дайтан “ялагч болсны улмаас бүгдийг татарчууд гэж нэрэлсэн”, “Араб, Хиндустан, Хятадад бас нэр алдартай”, “Хэт их сүр, нэр хүндтэй байсан” үе. Энэ үе Татарын хамгийн хүчирхэг үе бөгөөд Монголын төв болон зүүн хэсэг, зүүн талын хил зэргэлдээ нутгийг хамарсан хүчирхэг Татарын хаант улсыг байгуулсан үе. (842 оноос 923 он).

<sup>61</sup> Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2003. 378 дахь тал

<sup>62</sup> Лин Ган. Дунхугийн түүх. Хөх хот,1997. 375; Сундуй. Мончууд. Хөх хот.,1998. 91-96

<sup>63</sup> Дэлгэржаргал П. Шивэй аймгуудын угсаа-түүхийн зарим асуудал. МУИС-ийн НУФ-ийн ЭШБ. УБ.,2001. №8 (174). 107-115., Мэнгу шивэй аймгийн угсаа гарвалыг нэхэн сурвалжлах нь. МУИС-ийн ЭШБ.Түүх. №188 (14).УБ.,2002-т үзнэ үү.

<sup>64</sup> Дэлгэржаргал П. Мэнгу шивэй аймгийн угсаа гарвалыг нэхэн сурвалжлах нь. МУИС-ийн ЭШБ. Түүх. №188 (14).УБ.,2002. 10 дахь тал

Д) Татарын хаант улс задарч, Хятан улсын хараат болсон үе. (924 оноос XI зууны II хагас).

Е) Татарын гол цөм хэсэг (ноёлох овог аймгууд) Татар нэрээ хадгалан ханлиг хэлбэрээр оршин тогтнох болсон үе. (XI зууны II хагасаас 1202 он)

Дээрх судалгаандаа үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Татар хэмээх угсаатны нэрийдэл Жоужаны Датань хааны нэрээс үүсэлтэй нь Татарууд Монгол гаралтай болохын нэг нотолгоо төдийгүй хожим Монголчуудыг хөрш зэргэлдээ ард түмнүүд Татарууд хэмээн нэрлэсээр байсан нь үүнийг давхар баталж байгаа хэрэг юм.

2. Түрэгүүдэд цохигдон Жоужань улс мөхсөнөөр ноёлох овгийн нэг Монгол хэмээх овог аймаг Эргүнэ гүн тийш нүүдэллэн одож, үлдсэн Монгол угсааны аймгууд нутгийнхаа зүүн тал руу шахагдсан ч өөрсдийн төр ёс, соёл ахуйн уламжлалаа хадгалан "Гучин Татар" хэмээн нэрлэгдэн, Татарын нэгдэл-холбоо оршин тогтносоор байжээ.

3. Ашина аймгуудтай хийсэн тэмцэлд гучин Татарууд ялагдсанаар Татарын нэгдэл задарч, зарим аймгууд нь Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд орон, Түрэг аймгуудтай зэрэгцэн орших болж, тэдний улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилт болон угсаалжилтанд чухал үүрэг гүйцэтгэсээр байсан төдийгүй Кимакийн нэгдлийн гол цөмийг Татар аймгууд бүрдүүлсэн байна.

4. Ашина аймгуудад ялагдсан ч Татар аймгуудын гол цөм хэсэг нь улам бүр зүүншилж, Түрэг аймгуудтай холилдолгүй, харьцангуй бүхэллэг байж, улс төрийн нэгдэл, тусгаар тогтнолын голомтоо хадгалан ханлиг байдлаар оршин байсан бөгөөд тэднийг "Есөн Татар" хэмээн нэрийдэх болсон бололтой.

5. Уйгарын хаант улс мөхсөн 840-өөд оны үеэс Татарууд хүчирхэгжин Төв Азид Кидан, Киргизүүдтэй өрсөлдөхүйц улс төрийн хүчин болж гарч иржээ. Татарын хүчтэй эсэргүүцлийн улмаас Киргизүүд Монгол нутагт ноёрхлоо тогтоож чадаагүй бололтой. Киргизүүдтэй дайтан "Татарчууд ялагч болсны улмаас бүгдийг татарчууд гэж нэрэлсэн" төдийгүй "Араб, Хиндустан, Хятадад бас нэр алдартай", "Хэт их сүр, нэр хүндтэй байсан" үе нь 840-өөд оноос 923 он хүртэлх үед холбогдох бөгөөд энэ үеийг "Монгол-Татарын хаант улс"-ын үе гэж нэрлэж болно хэмээн үзэж байна. 6. Хятан улсын хараат болсноор Татарын хаант улс задарчээ. Гэвч XI-XII зуун гэхэд гол цөм мөхлөг нь Хөлөн Буйр нуур орчмоор нутаглан Татарын ханлиг хэлбэрээр оршин Төв Азийн түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэсээр байсан. 7. Хятан улсын нөлөө Монгол нутагт хэр их байсан, хэдийд Хятанчуудын ноёрхлоос Монгол угсааны аймгууд гарсан зэрэг нь төдийлөн тодорхойгүй байна. Монгол угсааны аймгууд Хятан улсын хараат байсан ч тэдний нөлөө төдийлөн их байгаагүй бололтой.

**Abstract:**

The records on Mongolian tribe unions is almost disappeared or in historical surveys during the Turkic state's period. At that time there are many records about Mengu Shivei tribes in Chinese chronicles but in Turkish and Uigur stone inscriptions no mention about them. However records about tribes named "thirty" tatars (Otuz tatars), "nine" tatars (Tokuz tatars) are mentioned. At that period some part of Mongol tribes migrated to the Ergune gun, remaining Mongol tribe unions were pushed to the eastern plain, kept statehood, cultural, livelihood traditions named "Otuz tatars" and "tokuz tatars" formed tatar tribe unions and polities.

**Ном зүй**

1. Ахимжанов С.А. Кыпчаки в истории средневекового Казакстана. Алмата. 1999.
2. Батсүрэн.Б. Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр.УБ., 2003.
3. Билэгт Л.Татары и Монголы. Археологийн судлал.Т .XVI, F.10, УБ.,1996
4. БНМАУ-ын түүх. I боть. УБ.,1966.
5. Болд Л. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ.,1990.
6. Болдбаатар Ж. Лундээжанцан Д. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997
7. Бромлей Ю.В. Очерки теории этноса.М.,1983
8. Васильев Д.Д. Корпус тюркских рунических памятников бассейна Енисея. Л.,1983
9. Грумм-Гржомайло Г.Е. Западная Монголия и Урианхайский край. Том.II.Л., 1926
- 10.Гумилев Л.Н. В поисках вымышленного царство. М., 1992
- 11.Дэлгэржаргал. Шивэй аймгуудын угсаа-түүхийн зарим асуудал. МУИС-ийн НУФ-ийн ЭШБ.УБ.,2001. №8 (174). 107-115
- 12.Дэлгэржаргал П. Мэнгу шивэй аймгийн угсаа гарвалыг нэхэн сурвалжлах нь. МУИС-ийн ЭШБ.Түүх. №188 (14).УБ., 2002
- 13.Дэлхийн түүх.I боть. (ред. Ж.Болдбаатар, З.Баасанжав). УБ., 2002
- 14.Peter B. Golden. Notes on the Qipchaq tribes: Kimeks and Yemeks. The Turks. Volume I. p. 660-670
- 15.Кляшторный С.Г.Стелы Золотого озера. (К датировке енисейских рунических памятников). –Turcologica: К семидесятилетию академика А.Н.Кононова. Л.,1976
- 16.Кляшторный С.Г. Государства татар в центральном азии /дочингисова эпоха/. Mongolica. К750-летию "Сокровенного сказания". М.,1993
- 17.Кызласов Л.Р. Ранние Монголы.(К проблеме истоков средневековой культуры). История и культура Востока Азии, т.III, Новосибирск, 1975
- 18.Кызласов И.Л. Рунические письменности евразийских степей. М.,1994.
- 19.Кычанов Е.И. Монголы в VI-первой половине XII в. Дальний Восток и соседние терротории в средние века: История и культура Востока Азии. Новосибирск, 1980
- 20.Лигети Л. Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Хэл зохиол судлал. Том VIII. Fasc 11.УБ.,1970. 321-339
- 21.Лин Ган. Дунхугийн түүх. Хөх хот,1997.
- 22.Лин Ган. Түрэгүүдийн түүх. Хөх хот,1995
- 23.Малов С.Е. Памятники Древнетюркской письменности монголии и киргизии. М-Л.,1959

24. Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2003
25. Монгол үндэсний нэвтэрхий түүх. I боть. Бээжин, 2002.(хятад хэлээр)
26. Монголын нууц товчоо. УБ., 1990
27. Мэн-да бэй-лу. Пер. с Китайского Н.Ц.Мункуева. М.,1975
28. Радлов В.В. Orhun. Атлась древностей монголии. (труды орхонской экспедиции). Санктпетербургъ, 1899. Ankara, 1995
29. Pelleot P. L'edition collective des oeuvres de Wang Kuo-wei.–TP.1929. vol.26
30. Пэрлээ Х. Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь. УБ.,1959
31. Пэрлээ Х. Хятан гүрний үеийн гурван мөрний эхний монгол аймгууд (907-1125). Эрдэм шинжилгээний өгүүллүүд. II боть. УБ., 2001. 294-298.
32. Пэрлээ Х. Гурван мөрний Монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь. Түүхийн судлал. Т.8, F.6, УБ.,1969
33. Рашид-Аддин. Судрын чуулган. (Сүрэнхорлоогийн орчуулга).I боть.УБ., 2002
34. Сундуй. Мончууд. Хөх хот.,1998.
35. Сүрбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Бээжин,1988
36. Сүхбаатар Г. Монгол нирун улс.УБ.,1992.
37. Talat Tekin, Orhon yazitlari. Ankara, 1986
38. Talat Tekin, Orhon yazitlari Kultigin, Bilge kagan, Tonyukuk. Stambul, 1998
39. Шинэхүү М. Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал. УБ.,1975
40. Хандсүрэн Ц. Жужаны хаант улс.УБ.,1994.
41. Хүүхэнбаатар Д. ред. Монголын түүхийн хураангуй хэрэглүүн.II. УБ.,1995